

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН 2024 ОНЫ
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2025.02.15

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, арга зүй

Зам, тээврийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын үйл ажиллагаанд 2024 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулж яамны удирдлага, албан тушаалтнуудыг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэв.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.1, 6.2.2, 6.3-т заасан аргачлалын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Хоёр. Танилцуулга

Бодлого, төлөвлөлтийн газар 2024 онд 5 чиглэлийн 138 арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажилласан ба нийт хэрэгжилт нь **84.5** хувьтай байна. Хэрэгжилтийн үнэлгээг хүснэгтээр үзүүлбэл:

/Хүснэгт 1/

№	Хяналтад байх арга хэмжээ	Нийт арга хэмжээ	Биелэлт /Хувиар/						Хугацаа болоогү	Үнэлгээ %
			100	90	70	50	30	0		
1.	Бодлого, төлөвлөлтийн газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	54	29	4	11	-	9	1	-	80%
2.	Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт	4	-	-	4	-	-	-	-	70%
3.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	52	34	-	17	-	1	-	-	89%
4.	Сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт	12	8	-	4	-	-	-	-	90%
5.	Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт	16	10	-	5	-	1	-	-	86.2%
	ДҮН	138	81	4	41	-	11	1	-	84.5%

2.1. Бодлого, төлөвлөлтийн газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт

БТГ-ын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 3 зорилтын 54 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд бүрэн хэрэгжсэн 100%-тай 29, хэрэгжих

шатанд 90%-тай 4, 70%-тай 11, хэрэгжилт хангалтгүй 30%-тай 9, 0%-тай 1 арга хэмжээ байна. Хэрэгжилтийн дундаж **80** хувьтай.

2.2. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тус газарт хамаарах нийт 4 заалтаар үүрэг даалгавар өгсөн ба хэрэгжилт 70%-тай байна.

2.3. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрээр 2024 оны жилийн эцсийн байдлаар тус газарт өгөгдсөн 5 шийдвэрийн 52 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж үнэлгээ 89%-тай байна. Хэрэгжилтийн үнэлгээг хүснэгтээр үзүүлбэл:

/Хүснэгт 3/

№	Шийдвэрийн төрөл	Арга хэмжээ	Хэрэгжилтийн үнэлгээ /хувиар/					ХШҮ
			100	70	30	0	Хугацаа болоогүй	
1.	МУ-ын хууль	4	2	2	-	-	-	85%
2.	УИХ-ын тогтоол	10	5	4	1	-	-	81%
3.	Ерөнхийлөгчийн зарлиг	2	-	2	-	-	-	70%
4.	Засгийн газрын тогтоол	13	8	5	-	-	-	88.5%
5.	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	23	19	4	-	-	-	95%
Нийт		52	34	17	1	-	-	89%

2.4. Зам, тээврийн сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт

Зам, тээврийн сайдын тушаалаар тус газарт нийт 12 заалтаар үүрэг даалгавар өгсөн ба бүрэн хэрэгжсэн 100%-тай 8, хэрэгжих шатанд 70%-тай 4 арга хэмжээ, хэрэгжилтийн дундаж 90%-тай байна.

2.5. Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт

Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар тус газарт нийт 16 заалтаар үүрэг даалгавар өгсөн ба бүрэн хэрэгжсэн 100%-тай 10, хэрэгжих шатанд 70%-тай 5, хэрэгжилт хангалтгүй 30%-тай 1 арга хэмжээ, хэрэгжилтийн дундаж 86.2%-тай байна. Хэрэгжилт хангалтгүй эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээг хүснэгтээр үзүүлбэл:

Гурав. Дүгнэлт

1.Бодлого, төлөвлөлтийн газрын 2024 оны жилийн эцсийн үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайд, ТНБД-ын тушаалын биелэлт гэсэн 5 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр **84.5%** үнэлэгдсэн байна.

2.Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан дараах ажлууд зорилтот түвшинд хүрээгүй байна. Үүнд:

- 2.1.Салбарын инновацийн төв байгуулах ажлыг эхлүүлэх;
- 2.2.Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх зам, тээврийн салбарын төлөвлөгөөг батлуулах Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх зам, тээврийн салбарын төлөвлөгөөг батлуулах;
- 2.3.Салбарын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөний төсөл батлуулах;
- 2.4.Салбарын хүний нөөцийн 2024-2030 он хүртэл хөгжүүлэх төлөвлөгөөг батлуулах;
- 2.5.Салбарын бодлогын болон техник, технологийн чиглэлээр судалгаа хийх;
- 2.6.Шинжлэх ухаан, технологийн их сургуультай хамтран зам, тээврийн салбарын судалгаа, шинжилгээний төвийг байгуулах бэлтгэл ажлыг эхлүүлэх;
- 2.7.Е-Mongolia цахим үйлчилгээний нэгдсэн порталд зам, тээврийн салбарын үйлчилгээг нэмэгдүүлэх;
- 2.8.Цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх;
- 2.9.Зам, тээврийн салбарын цахим үйлчилгээний төвийг ашиглалтад оруулж, үйлчилгээг гар утаснаас авах боломжийг бүрдүүлэх;
- 2.10.“Асуудал, шийдлийн систем”-ийг хөгжүүлж иргэдийн санал, гомдлыг цахимаар авч, боловсруулан бодлого төлөвлөлтөд ашиглах.

Дөрөв. Санал, зөвлөмж

1. Үр дүнгүй буюу 0-30 хүртэл хувийн хэрэгжилттэй гэж дүгнэгдсэн-1, эрчимжүүлэх шаардлагатай буюу 31-69 хүртэл хувийн хэрэгжилттэй-11 арга хэмжээг эрчимжүүлж, хэрэгжилтийг хангах;

2. Түүнчлэн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа зарим зорилт, арга хэмжээний хүрэх түвшин, хугацааг бодитой төлөвлөөгүй нь тухайн арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээнд сөргөөр нөлөөлөх нөхцөл үүсэхийг анхаарч, цаашид төлөвлөлтийг бодитой үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөх;

3. Албан хаагчид гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнахдаа зорилт арга хэмжээний гүйцэтгэл хүрэх түвшинд хүрсэн эсэх, хүрээгүй бол шалтгаан, нөхцөлийг товч тодорхой, тоо баримттай, цаг хугацаанд нь албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдсөн байх;

4. Дээд шатны байгууллагад хүргүүлэх хэрэгжилтийн тайланг боловсруулахдаа тухайн зүйл, заалтаар өгөгдсөн үүрэг даалгаварт хамаарах хэрэгжилтийг оновчтой, тодорхой байдлаар, хүрсэн үр дүнг хоёр мянган тэмдэгтэд багтаан гаргах, холбогдох тушаал шийдвэр, албан бичгийн огноо, дугаарыг тодорхой бичих, заасан хугацаанд холбогдох нэгжид хүргүүлж, ХШҮДАГ-аар үнэлүүлж байх арга хэмжээ авч ажиллахыг зөвлөж байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА